



“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/26 тоот тогтоолын
1 дугаар хавсралтаар батлав

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БОЛОН БУСАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “Инновэйшн Инвестмент” ХК (*цаашид* “Компани” гэх)-ийн зүгээс хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон Компанид үйлчилгээ үзүүлж буй этгээд, түүнчлэн, бусад оролцогч талуудтай хэрхэн харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Компанийн тухай хууль, Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хороо (*цаашид* “Хороо” гэх), Монголын Хөрөнгийн Биржээс баталсан холбогдох дүрэм, журмууд болон бусад хууль, тогтоомжийг удирдлага болгоно.
- 1.3. Хөтөлбөрт хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. “Хувьцаа” гэж хөрөнгө оруулагчаас Компанид оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг;
 - 1.3.2. “Үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д тодорхойлсон санхүүгийн хэрэгслийг;
 - 1.3.3. “Хороо” гэж хууль тогтоомжид заасан зохицуулагч байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хороог;
 - 1.3.4. “Хөрөнгө” гэж Компанийн өмчлөлд буй бүх төрлийн санхүүгийн хэрэгсэл, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг;
 - 1.3.5. “Хөрөнгө оруулах хэлбэр” гэж Компанид хөрөнгө оруулалт татахаар зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгслүүдийг;
 - 1.3.6. “Бусад оролцогч” гэж Компанийн үйл ажиллагаанд шууд буюу шууд бусаар оролцож буй аливаа этгээдийг тус тус ойлгоно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛГАА

- 2.1. Энэхүү хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн нь:
 - 2.1.1. Хөрөнгө оруулагч, Компанийн хувьцаа эзэмшигч, Компанид үйлчилгээ үзүүлж буй аливаа этгээдүүд, аудит болон бусад оролцогч талуудад тогтмол хугацаанд үнэн зөв мэдээллээр хангах;
 - 2.1.2. Компанийн засаглалын тогтолцоог сайжруулах;
 - 2.1.3. Компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх;
 - 2.1.4. Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад оршино.
- 2.2. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - 2.2.1. Мэдээлэл хүргүүлэх хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, ТУЗ, болон бусад оролцогчдын жагсаалтыг гаргах;
 - 2.2.2. Мэдээлэл хүргүүлэх баримт бичгийн бүрдлийг хангах;

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1. Энэхүү хөтөлбөрийг ТУЗ нь үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгт нийцүүлэн баталж, холбогдох баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэнд хяналт тавина.
- 3.2. ТУЗ нь Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журамд заасны дагуу дараах мэдээллийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон зохицуулагч этгээд, бусад оролцогч этгээдэд тайлагнах, тараах хугацаа, арга замыг тогтооно. Үүнд:

№	Тогтмол мэдээллийн төрөл	Ирүүлэх	Хуулийн үндэслэл	Хугацаа
1	Жилийн санхүүгийн тайлан	эцсийн	ҮЦЗЗТХ 20.1.6, НББ хуулийн 10.3	Жил бүрийн 2 дугаар сарын 10-ны дотор
2	Ногдол эсэх шийдвэр	ашиг тараах	КТХ 46.5	Санхүүгийн жил дуусснаас хойш 50 хоногийн дотор буюу жил бүрийн 2 дугаар сарын 19-ний дотор
3	Хувьцаа хурлын мэдэгдэл	эзэмшигчдийн ээлжит	КТХ 60.3, 60.4 СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 3.1	Жил бүрийн 03 дугаар сарын 21-ний дотор +/3-5 хоног/
4	Аудитын дүгнэлт		ҮЦЗЗТХ 20.1.6 Аудитын тухай хууль 10.2 НББ хууль 9.7	ХЭ ээлжит хурлаас 2-оос доошгүй 7 хоногийн өмнө
5	Жилийн ажиллагааны тайлан	үйл	СЗХ-ны бүртгэлийн журмын 10.7, Хавсралт 4-ын Маягт 1	Жил бүрийн 03 дугаар сарын 31-ний дотор
6	1-р улирлын ажиллагааны тайлан хүргүүлэх	үйл	СЗХ-ны бүртгэлийн журмын 10.7, Хавсралт 4-ын Маягт 2	Жил бүрийн 04 дүгээр сарын 20-ны дотор
7	Хувьцаа хурал хуралдуулах сүүлийн хугацаа	эзэмшигчдийн ээлжит	КТХ 59.4	Жил бүрийн 04 дүгээр сарын 30-ны дотор
8	Хувьцаа хурлаас шийдвэр, тэмдэглэл	эзэмшигчдийн ээлжит гарсан	КТХ 74.1, 56.1.6, 56.2.3, СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.10	Хурал хуралдснаас хойш ажлын 3-15 өдрийн дотор
9	Хагас санхүүгийн болон ажиллагааны тайлан хүргүүлэх	жилийн үйл	НББ хуулийн 10.3, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.7, Хавсралт 4-ын Маягт 2	Жил бүрийн 07 дугаар сарын 20-ны дотор
10	3-р улирлын ажиллагааны тайлан	үйл	Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.7, Хавсралт 4-ын	Жил бүрийн 10 дугаар сарын 20-ны дотор

АНХААТАР

ИНОВЭЙ
ИНВЕСТМЕНТ
ХК

ТЦ867 6183948 9

Маягт 2			
11	Тухай бүр нийтэд мэдээллэх мэдэгдэл	ҮЦЗЗТХ 56.1, 56.2, Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.8, 10.9, Хавсралт 4-ын Маягт 3	Тусгай нөхцөл байдал үүсснээс хойш ажлын 1-2 өдрийн дотор
12	Ногдол ашиг хуваарилалтын тайланг ХЭХ-д тайлагнах, МХБ-д хүргүүлэх	КТХ 46.14, 46.15	ХЭХ хуралдсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор
13	Жилийн үйлчилгээний хөлс төлөх	Үнэт цаасны бүртгэлийн журмын 22.11, Бүртгэлийн гэрээ 2.1.3, 2.4	Жил бүрийн 03 дугаар сарын 31-ний дотор
14	Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг хүргүүлэх	Компанийн засаглалын Кодекс	Хагас жил, жилийн эцсээр, СЗХ-ноос шаардсан тухай бүр

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ ХЭРЭГСЭЛ, ХЯНАЛТ

- 5.1. Мэдээллийг холбогдох нэгж буюу нэгжийн хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн зөв эх сурвалжуудыг ашиглан боловсруулах ба компанийн цахим хуудас, имэйл хаяг, Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагын цахим хуудас, холбоо харилцааны хэрэгслүүд, биечилсэн уулзалт, олон нийтийн мэдээллийн сувгуудын нэгийг буюу хэсгийг ашиглан хөрөнгө оруулагчид болон олон нийтэд мэдээлэл хүргэнэ.
- 5.2. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь Хөтөлбөрийн үйл ажиллагааны мэдээлэл, тайлагналтай холбоотой үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомж, компанийн засаглалын кодексст нийцэж буй байдалд хяналт тавих, хөтөлбөрт сайжруулалт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК

---oOo---



**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 05/26

Улаанбаатар хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БОЛОН БУСАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 9.6.17 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Инновэйшн Инвестмент ХК-ийн “Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр”-ийг Хавсралт-1 ёсоор баталсугай.
2. Батлагдсан хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд, Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР